



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 5 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 196

Улаанбаатар  
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт  
оруулах тухай

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 10.1.5-д заасныг үндэслэн  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар  
тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах  
мэдээллийн жагсаалт"-ын в,к,л хэсэгт дор дурдсан агуулгатай дараахь заалт  
нэмсүгэй:

"в/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар" хэсэгт:

№	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл		Нууцлах хугацаа (жилээр)
		Онц чухал нууц	Маш нууц	
32	Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил, түүнд оролцуулах зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийн тоо хэмжээ болон ус хангамжийн эх үүсвэр, худалдан авах үйл ажиллагааны нууцалбал зохих хэсэг		+	20

"к/ Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар" хэсэгт:

11	Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил, түүнд оролцуулах зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийн тоо хэмжээ болон ус хангамжийн эх үүсвэр, худалдан авах үйл ажиллагааны нууцалбал зохих хэсэг		+	20
----	---	--	---	----

"л/ Зам, тээврийн салбар" хэсэгт:

10	Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил, түүнд оролцуулах зэвсэгт хүчний бие		+	20
----	--	--	---	----

бүрэлдэхүүн, техник хэрэгслийн тоо хэмжээ болон ус хангамжийн эх үүсвэр, худалдан авах үйл ажиллагааны нууцалбал зохих хэсэг			
--	--	--	--



У.ХҮРЭЛСҮХ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ
